

**2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ
ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

2021.07.02

№	Үүрэг даалгавар	Хариуцах хэлтэс	Хэрэгжилт
1	CallPro үйлчилгээтэй холбоотой холбогдох дутуу орсон байгууллагуудыг хамруулах	ЗДТГ-ын хэлтсүүд, бусад холобогдох хэлтэс, агентлагууд	Авто тээврийн төв, Татварын хэлтэс 2-оос бусад байгууллагуудын холболт бүрэн хийгдсэн, үйл ажиллагаа нь жигдрээд явагдаж байна. Авто тээврийн төв, Татварын хэлтэст албан бичгээр чиглэл өгөв.
2	Аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахлийн өвчлөл буурахгүй, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаа энэ нөхцөл байдлын улмаас хэлтэс, агентлагын дарга нар 07 дугаар сард ээлжийн амралт эдлэхгүй. Ямар ч хэлтэс, агентлагын дарга 07 дугаар сард амрахгүй шүү.	ЗДТГ-ын хэлтсүүд, бусад холобогдох хэлтэс, агентлагууд	Төр, төсвийн байгууллагын дарга, захирал нарт албан бичгээр чиглэл хүргүүлсэн.
3	Салбарын сайдуудтай байгуулсан эхний хагас жилийн гэрээний биелэлтийг хугацаанд нь гарга. Хугацаа нь бараг тулчихсан байна. Үүнийг тоо чанарын өндөр үзүүлэлттэй гаргаж ТЗУХ-т ирүүлнэ. Үүнийг бүх байгууллагууд анхааралдаа ав. ТЗУХэлтэс хагас жилээр явах хугацаатай тайлан мэдээг цаг хугацаанд нь явуулна шүү. Энэ байгууллагуудаас шаардлагаа тавиад ав.	ЗДТГ-ын хэлтсүүд, бусад холобогдох хэлтэс, агентлагууд	14 сайрд, 2 дээд байгууллага /ЗГХЭГ, ҮХГ/-ын нийт 16 гэрээсээ 2021 оны эхний хагас жилийн байдлаар 8 сайдын гэрээний хэрэгжилтийг хүргүүлэх ба 6 сайдын гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлж 2 сайдын гэрээг 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэхээр байна. /Хугацаа болоогүй/ ЗГҮАХ, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэтгэж ХШҮДАХ-т хүргүүлэн ЗДЗХ-танилцуулагдаж ЗГХЭГ-т хугацаанд хүргүүллээ.
4	Хууль эрх зүйн хэлтсээс шинээр батлагдсан хууль болон боловсруулагдаж байгаа хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Цахимаар сургалт сурталчилгаа явуулах ажлыг Хууль эрх зүйн хэлтэстэй хамтарч зохион байгуул.		“Тодруулга ярилцлага”, “Хуулийн цаг нэвтрүүлэг”-ээр тус тус 2 удаа шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийсэн. Мөн УБХ, НДХ, ШШАлбаны нийт 65 гаруй албан хаагчдад цахимаар сургалтыг зохион байгуулсан.
5	“Ногоон Дархан” хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудад нийтийн эзэмшлийн зам талбайгаас хуваарилах, хуваарийг гаргаж албажуулж хүргүүлэх. Мөн холбогдох хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах	ТЗУХ, ЗАА	- Аймгийн засаг даргын 2021 оны 01-А/133 тоот “Ногоон Дархан” төслийн хүрээнд Нийтийн зориулалттай орон сууцны хороололд 2021-2024 онуудад ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр БОАЖГ, ЗАА, СӨХ-д нь “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Мөн БОАЖГ-аас СӨХ-дод 200 ширхэг монос мод өгсөнийг

			<p>зааврын дагуу тарьсан. Нийт 580 ш мод бутыг шинээр нэмж тарьж усалгаа арчилгааг тогтмол хийж байна.</p> <p>- Сууц өмчлөгчдийн холбоод нь Ногоон байгууламжийг хамгаалж шинээр 390 м хашаа хайсыг хийсэн бөгөөд хуучин хашаа хайсыг сэргээн засварлах, өнгө үзэмжийг сайжруулах зэрэг тохижилтын ажлуудыг гүйцэтгэж байна.</p>
6	<p>Өнгөрсөн пүрэв гарагт Шарын гол дээр байнгын ажиллагаатай байдаг постны вагончик хүчтэй салхины улмаас унаад 10-аад метр газар өнхөрсөн байна. Дотор нь тухайн үед үүрэг гүйцэтгэж байсан хоёр хүн бэртэж гэмтсэн асуудалд гарсан. Төрийн бус байгууллагын ажилтны бие харьцангуй хөнгөн гэсэн мэдээлэл авсан, харин цагдаагийн алба хаагч нь нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасагт байгаа. Дотуур гэмтэл их авсан мэдээлэл байна. Албан үүргээ гүйцэтгэж явсан алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг нь анхаарч, хяналт тавих</p>	НБХ, ХЭЗХ,	<p>Цагдаагийн албан хаагчийн биеийн байдал сайжирсан нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна.</p>
7	<p>“Ногоон Дархан” хөтөлбөрийн хүрээнд явж байгаа хар шорооны асуудлын зардлыг шийдвэрлэх</p>	ХОХБТХ	<p>Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 7 төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан бэлтгээд байна. Энэ 7 төсөл арга хэмжээний ажил дотор хар шороо нийлүүлэх 4,0 сая.төгрөгийн ажлыг оруулсан байна.</p>
8	<p>Хүслийн хотхон руу шинээр зам тавигдаж байгаагаар холбоотой энэ хагас сайн өдөр ХОХБТХ-ийнхэнтэй уулзаж газар дээр нь танилцаад сургууль, цэцэрлэг рүү болон аж ахуй нэгж байгууллагын дэлгүүр лүү нь орц гарц хийх асуудлаар ярилцая гэсэн боловч бас утсаа авсангүй. Уг нь цаг нараа товлоод тохирсон байсан. Цаана нь иргэд бас хүлээлтийн байдалтай байгаад байдаг гарц хийж болох юм уу, болохгүй юм уу, болохоор бол тэр гүйцэтгэж байгаа компанитай нь асуудал ярихгүй бол зургийн төслөө өөрчлөхгүй гэсэн юм яриад байдаг. Бодит амьдралтай уялдуулж зураг төслөө хийдэг баймаар байна. Нэгэнт газар дээр нь хийж байгаа болохоор ямар ч зардал гарахгүйгээр шийдчих боломж бололцоо байж байхад ХОХБТХ-ийнхэн хариу өгөхгүй</p>	ХОХБТХ	<p>Шийдвэрлэх боломжгүй.</p> <ol style="list-style-type: none"> 1.Өргөсөлтөн дээр гарц гаргах боломжгүй. 2. Гарц хоорондын зай хангагдахгүй байна. <p>Шинэ хорооллын 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзвараас хүслийн хотхон чиглэлийн шинээр хийгдэж байгаа авто зам дагуу 300 метр газарт 3 гарц гаргасан.</p>

	юм.		
9	Мэдээлэл технологийн албан дээр Bloomberg-ийн мэдээлэл технологийн төсөл бичсэн хүний зардлын асуудлыг шийдвэрлэх	ХОХБТХ	Аймгийн Засаг даргад танилцуулагдаагүй байна.
10	Пасад засвар хийж байгаа орон сууцнууд бүгд сайхан болж байна. Баруун дээд булан дээр нь дугаарлалт хийх асуудал	ХОХБТХ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжиж байгаа “Нийтийн эзэмшлийн орон сууцны засвар, шинэчлэлт” XII.2.40 хуулийн дугаартай, УТХО 2021-01/02 гэрээт ажлыг 797,035,748 төгрөгөөр гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 78%-тай байгаа бөгөөд 2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 400,000,000 төгрөгөөр, 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 397,035,748 төгрөг санхүүжихээр байна. Үндсэн гэрээний ажлаа гэрээт хугацаандаа дуусгаад нэмэлтээр үүрэг даалгавар өгөгдсөн гэрээнд тусгагдаагүй орон сууцны байруудын дугаарлалтын ажлыг хийхээр мэдэгдсэн.
11	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ЕБС, цэцэрлэгүүдэд Захирагчийн ажлын албанаас чиглэл өгөгдсөн. Захирагчийн ажлын албанд тохижилтын ажилд 05 дугаар сард чиглэл өгөгдсөн. Төрийн болон төрийн бус байгууллага хувь иргэд бүх аж ахуй нэгж байгууллагуудад 7 чиглэлийн үүрэг чиглэл өгөгдсөн./ Гадна хаяжилт, тохижилт, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт гэх мэтчилэн./ Энэ чиглэлээр ямар ажил хийгдэж байгаа талаарх мэдээлэл	ЗАА	БСУГ, Эрүүл мэндийн газарт өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө, нэн шаардлагатай хийх ажлын эзэлхүүн, төсөв ирүүлэхийг шаардсан боловч ирүүлээгүй байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах Аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж танилцах хуудас тойруулж Засаг даргаар батлуулахаар өгсөн.
12	“Миний монгол” цэцэрлэгт хүрээлэнгийн хонины орд, нийтийн жорлонг засаж сайжруулж янзлах чиглэлээр анхаарч ажиллах	ЗАА	Миний Монгол цогцолборын Хонины ордыг сэргээн засварлах, ОО-ын засварын ажлыг “Ган хүдэр орд” ХХК 7 дугаар сарын 10-с эхлэн 9 дүгээр сард багтаан ашиглалтанд өгөхөөр зураг төслийн ажил хийгдэж байна.

13	Газар шорооны ажил хийж байгаа компаниуд, барилгын ажил хийж байгаа хүмүүсийг Бараат хогийн цэг рүү шороог нь ачуулах чиглэлээр ажил өрнүүлж байгаа. Үүнийг ямар ямар байгууллагууд руу барилгын ажил суурь хундамаа ухаад гарч байгаа шороонуудыг ямар чиглэлээр Бараат руу өгөх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний явц	ХОХБТХ	Дархан сумын 6-р багт Бараат хогийн цэгийг дарж булшлах ажил 100% хэрэгжиж дууссан. 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсэг ажиллана.
14	Бараат хогийн цэг дээр барилгын хог асгаж байгаа дээр хяналт тавих байцаагчаа байнгын байлгамаар байна. Асгаж байгаа барилгын шороог жалга руу оруулж булах, түрэх асуудал дээр онцгой анхаараад техник хэрэгслээ байнгын тогтмол ажиллуулах чиглэлээр анхаарч ажиллах	НААҮГ	Бараат хогийн цэгт Ган хүдэр ХК-ны экскаватор, НААҮГ-ын Т160 гинжит трактор 2 ширхэг хово машин ажиллаж байна. Өдөр бүр батлагдсан хуваарийн дагуу эргүүл ажиллуулж байна.
15	Аюултай хогийн цэг байгуулах асуудал ажил эхэлсэн явж байгаа юм байна лээ. Явц нь ямар байна. Онцгой байдлын газар дээр бичиг цаас нь гацсан асуудал байна. Тэрийг яаралтай хөөцөлдөж шийдүүлж ажлын даалгавартай холбоотой асуудлууд дээр анхаараарай. Үерийн байгууламжийн цэвэрлэгээний асуудал байна. Нийтийн аж ахуй үйлчилгээний газар, сумдуудтай холбоотой асуудал байна. Бороо ихээр орж байна. Цаашдаа ч их орох төлөвтэй байх шиг байна. Сумдууд үерийн байгууламжийн цэвэрлэгээг хийх, дахин нэг эргэж харж цэвэрлэгээн дээрээ анхаарахгүй бол асуудал хүндрэх вий. Анхаараарай.	НААҮГ	Дархан сум 13-р баг, Үйлдвэрийн бүсэд барих Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилгын ажлын хүрээнд 2021.07.01 өдрийн дугаар 21/44 архитектур төлөвлөлтийн даалгаварыг аймгийн ерөнхий архитетороор батлуулсан. Аймгийн Онцгой байдлын газраар зургийг батлуулсан. Барилгын ажил эхлээгүй байгаа. НААҮГ-ын өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцдаг Үерийн далан сувгуудад үзлэг хяналт хийж байна. 5 дугаар багийн үерийн далангийн гүн цооногт мэргэжлийн байгууллага техникийн оролцоотойгоор таг хийх зайлшгүй шаардлагатай байгаа. Мөн ЗАА, Дархан сумын ЗДТГ-аас Эрчим хүч инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай хамтран цэвэрлэгээ үйлчилгээ хийхээр бэлтгэл ажил хангаж байна.
16	Хороолол доторхи шарилж устгалтай холбоотой асуудлыг онцгой анхаарах	НААҮГ	“Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийн хүрээнд НААҮГ-аас 6 дугаар сарын 11-ээс 6 дугаар сарын 26-ний өдрүүдэд НААҮГ-ын хамааралтай буюу эзгүй талбайн нийт 141 га-д хог ургамлын устгалын 1 дүгээр шатны ажлыг 100% гүйцэтгэж дууссан. Мөн Сууц өмчлөгчдийн холбоодод “Хог ургамлын төрөл, хэрхэн устгах, сонголмол үйлчилгээтэй хорыг хэрэглэх заавар” сэдвээр 2021.06.14-нд сургалтыг зохион

			байгуулсан. СӨХ-д орон сууцны хороолол доторх 16 га газарт хор цацах, тайралт, таналт хийх зэргээр устгалыг хийж байна.
17	Хотын А бүсэд байгаа газар авсан эзэмшиж байгаа этгээдүүдийг цэгцлэх асуудал байна. Энэ чиглэлээр ямар ажил арга хэмжээ зохион байгуулж байна вэ. Ямар шатандаа явж байна.	ХОХБТХ, ЗАА	Дархан сумын хэмжээнд хотын А бүсэд нийтийн зориулалттай орон сууц, үйлдвэр үйлчилгээний барилгын зориулалтаар авсан 34 иргэн, хуулийн этгээдэд газар байна. Одоогоор <ul style="list-style-type: none"> - Барилгын ажил 2021 онд эхэлсэн болон өмнөх оны төсөл үргэлжилж байгаа - 12 - Барилгын ажил явагдахгүй байгаа /суурь ухсан, карказтай, 1-2 дахварын ажил явагдаад зогссон/ - 16 - Барилгын ажил огт явагдаагүй хашаа татсан - 6 Барилгын ажил явагдахгүй байгаа иргэн хуулийн этгээдүүдэд мэдэгдэл өгч засвар үйлчилгээг, харуул хамгаалалт тавьж ажиллахыг мэдэгдсэн.
18	“Миний монгол” цэцэрлэгт хүрээлэнд төрийн албан хаагчдын орд гээд арслангын орд байна. Үүнийг засаж сайжруулах чиглэлээр анхаараарай.	ЗДТГ	ХОХБТХ болон НҮА хамтран газар дээр нь очиж танилцан яаж хэрхэн засаж сайжруулж тохижуулах талаар санал солилцсон.
19	Боловсрол, соёл урлагын газраас ирж байгаа мэдээллүүд хангалтгүй байна. Над дээр орж ирж танилцуулагдаж байгаа мэдээллүүд статистик тоон мэдээ судалгаа дулимаг байна. Хэдэн тоон мэдээнүүдийг нэмээд тавихад зөрүүтэй байдаг мэдээлэл гаргаж ирж байна. Жишээлбэл төгсөгчдийн тоо маш их зөрүүтэй, алдаатай явж байна. Боловсрол, соёл урлагын газрын мэргэжилтнүүдийн цаг ашиглалт туйлын хангалтгүй байна. Би хэд хэдэн удаа ажлын цагаар нь хувиаарийг нь харж байгаад яваад орохоор ерөөсөө л ганц хоёр хүн сууж байх юм. ЭЕШалгалт дөхчихсөн 07 дугаарын 01-нд болно гэж байхад мэргэжилтнүүд нь ажлын байран дээрээ байхгүй байна. Саяхан харин шийдвэр гараад хойшиллоо. Энэ юу болж байгаа юм бэ. Бүхэл бүтэн аймгийн боловсролын бодлогыг барьж байгаа байгууллага ийм хариуцлагагүй ажиллаж болдог юм уу. Энэ дээр арга хэмжээ аваад ажилла. ЭЕШалгалт 2021 оны 08 дугаарын хоёрдугаар хагас руу шилжсэн. Сайд нь тодорхой 11 шалтгаантай мэдэгдэл хийсэн. Үүнтэй холбоотой Боловсролын үнэлгээний газар луу саналыг явуулж, халдвар хамгааллын дэмлэмийг бариулаад	НБХ	Аймгийн БСУГазраас Боловсролын үнэлгээний төвд хүсэлт гаргаж Элсэлтийн ерөнхий шалгалт авах байрыг Оюуны ирээдүй А,Б байр, Од цогцолборын А байрыг нэмэгдүүлж нэг ангид 12-15 хүүхэд байхаар зохицуулалт хийгдсэн.Аймгийн хэмжээнд 1249 төгсөгч байна. БСУГазар Аймгийн онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу албан хаагчдийг 30 хувиар ажлуулж байна.Мөн тухайн үед гэрийн тусгаарлалтад 3 хүн байсан.

	ЭШалгалт авах цэгийн тоог нэмэгдүүлэх тал дээр ажиллана аа нийгмийн бодлогын хэлтэс.		
20	Соёлын хэлтэс Дархан-уул аймгийн ЗДТГ-ын дэргэд байгуулагдахаар болж байна. Соёлын хэлтэс байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах	НБХ	Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас орон нутагт соёлын хэлтэс байгуулах чиглэлийг ирүүлээгүй байна.
21	“Оюунлаг Дарханчууд” дэд хөтөлбөрийн боловсруулалтыг анхаарч ажилла.	НБХ	Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Хүний хөгжил,хөдөлмөр нийгмийн бодлогын хяналтын хороогоор 2021.06.29-ний өдөр хэлэлцүүлж санал авсан
22	Цахим арга хэмжээнүүдийг чанартай зохион байгуулах тал дээр БТСГазар анхаарах хэрэгтэй байна. Онлайн сургалт, дасгал хөдөлгөөний ажлыг БТСГ ерөөсөө хийхгүй байна.	НБХ	Дархан-Уулын гүйгчид – 2021 фэйсбүүк группыг 03 дугаар сарын 01-ний өдрөөс нээж цахим гүйлтийн болон алхалтын аяныг БТСУХ-ноос гаргасан тусгай удирдамжийн дагуу зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган ажиллах, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэн өдөр тутмын эрүүл зөв амьдралын хэв маягыг хэвшүүлж биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж, бие бялдраа чийрэгжүүлж халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих зорилготойгоор 06 дугаар сарын 02 – 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд Цахим алхалт, дугуйн арга хэмжээг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 430 хүн нийт 7290км зам туулсан байна. Тус арга хэмжээний дүнг 07 дугаар сарын 02-нд гаргаж, идэвхтэй хамрагдсан иргэдэд өргөмжлөл, мөнгөн урамшууллыг гардуулна.
23	Үндэсний статистикийн хорооноос баталсан өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалын дагуу 310 буюу түүнээс доош оноотой өрхөд хүнсний эрхийн бичиг олгодог. Дархан-Уул аймагт энэ асуудалтай холбоотой асуудал дээр хяналт тавьж ажиллахгүй бол ямар ч шаардлагагүй хувьдаа байртай, хувийн хаустай, машинтай хүн хүнсний талон аваад явж байна. Энэ юу болж байна вэ. Энийг цэгцлэх хэрэгтэй. Би биечлэн очиж үүрэг даалгавар өгсөн. Энэ дээр ажиллана аа. Засгийн газраас зорилтот бүлгүүд рүү чиглэсэн олон арга хэмжээ хэрэгжүүлж байна. Энэ зорилтот бүлэг рүүгээ хүрэхгүй байгаа учраас иргэдийн бухимдал үүсээд байна. Журман	НБХ	Дархан-Уул аймгийн хэмжээнд 2021 оны хагас жилийн байдлаар 1314 өрхийн 3812 том хүн, 3813 хүүхэдэд 91,496,000 төгрөгийн Хүнсний эрхийн бичиг олгогдсон байна. 2020.10.30-ны удирдамжаар 23 өрхийн 68 том хүн, 48 хүүхэд, Мэргэжлийн хяналтын газрын 2021.06.29-ний өдрийн №10-06-046/79 тоот шаардлагын дагуу хүнсний эрхийн бичиг олгох цуцлах журмын 5.1.5 дахь хэсгийг үндэслэж 36 өрхийн 164 том хүн, 98 хүүхдийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс тус тус түдгэлзүүлсэн байна.

	<p>дээр нь хяналт тавьж сар бүр шинэчилж явж байх ёстой. Яагаад удаан хугацаатай явсан юм бэ. Энэ дээр анхаарах ёстой. Халамжийн 17 үйлчилгээ цахимжиж байгаатай холбогдуулан төрийн албан хаагчдын ажлын ачаалал тодорхой хэмжээгээр буурч байгаа. Тэгэхээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар цаашид хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төвлөрч ажиллах ёстой. “Халамжаас хөдөлмөрт” дэд хөтөлбөр, “Цагийн ажил” төслийг хэрэгжүүлж ажиллах шаардлага байна. Энэ бол Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн чухал заалтууд. Монгол улсын Ерөнхий сайд тодорхой чиглэл өгсөн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болоод Засаг даргын ажил хийж байгаа байдлыг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар хэмжинэ гэсэн. Тухайн аймаг хичнээн хүн хөдөлмөр эрхэлдэг, шинээр хамрагдсан байдал, өмнөх түвшнгээсээ буураагүй байх нөхцлийг харна гэж мэдэгдсэн. Энэ дээр анхаарах.</p>		<p>Халамжаас хөдөлмөрт дэд хөтөлбөрийн хүрээнд 525 өрхийн 475 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулж хувь хүний хөгжлийн сургалтыг 4 сумын хэмжээнд зохион байгуулсан.Цагийн ажил төслийг 2021 оны 09 дүгээр сараас хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>
24	<p>Цахим үйлчилгээгээ нэвтрүүлж тогворжуулах. Дархан-Уул аймгийн иргэдийн хамгийн их үйлчилгээ үзүүлдэг гурван төрийн байгууллага байдаг. Үүнд: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс. Иргэд хамгийн их биечлэн очиж үйлчлүүлдэг. Эдгээр байгууллагуудад цахим үйлчилгээг нэвтрүүлэх тал дээр холбогдох удирдлагууд болон байгууллагын удирдлагууд санаачлагатай ажилла. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт дээр шимтгэлийн орлогыг 5.9 тэрбум төгрөгөөр баталсан. Одоо гүйцэтгэл 5.2 тэрбум төгрөг гэж гарч байна. Н.Цасчихэр дарга аа ингээд оны эцэст гүйцэтгэл тасарсан гээд асуудал гардаг. Энэ дээр яагаад ийм зөрүү гарсан шалтгааныг олж тогтоо.</p>	НБХ	<p>Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын сайт http://www.darkhan-ndaatgal.gov.mn/ болон пэйж хуудсанд өдөр тутам нийтэлж, иргэд, даатгуулагчдад мэдээлэл өгч ажиллав. Тайлант хугацаанд 15 мэдээг албан ёсны сайтад нийтэлсэн болно. Мөн хэлтсийн facebook хуудсаар дамжуулан 2021 оны эхний хагас жилийн байдлаар 89 удаагийн мэдээ мэдээллийг олон нийтэд өгч ажиллаж байна. 2021 оны 06 сарын 27-ны байдлаар 18 удаагийн шууд LIVE хийж 365589 иргэд үзсэн бөгөөд 1871 иргэний асуутанд хариулж шууд бичлэгийг 1219 удаа шэйр хийж олон нийтэд хүргэсэн.Нийгмийн даатгалын тодорхойлолт, шимтгэл төлөлт, архивын лавлагааг цахимаар үзүүлж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь нийгмийн халамжийн 13 үйлчилгээг цахимаар үзүүлж 5 үйлчилгээг энэ онд багтаж бүрэн цахимд шилжиж дуусна. ХНХ-ын сайдтай байгуулсан гэрээний нийгмийн даатгалын шимтгэл орлогын төвлөрүүлэлт нь</p>

			зөрүүтэй батлагдсан учир ХНХЯамны Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэнд мэдэгдэж жилийн эцэст тайлбарыг бичиж ирүүлэхийг зөвлөсөн.
25	Улсын бүртгэлийн хэлтэст орон нутгийн төсвөөс 10 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтаар албан хэрэгцээнд ашиглах компьютер техник хэрэгсэл авахаар гэрээнд тусгагдсан. Гэрээний заалтыг хангуулахаар 02 дугаар сард төсөв хийгээд ХОХБТХ-г өгсөн. Үүний хэрэгжилтийг хангуул.	ХЭЗХ, ХОХБТХ	Аймгийн Засаг даргад танилцуулсан. Шийдвэрлэгдээгүй байна.
26	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.3 дахь арга хэмжээн дээр Бэлгийн хүчирхийллийн хохирогчийг сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээнд хамруулах, нөхөн сэргээх, үүрэг хүлээгчдийг чадавхижуулах, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, судалгааны байгууллага, судалгаа хийх гэж ажил төлөвлөгдсөн байгаа. Цагдаагийн газар энэ ажил дээр төлөвлөгөө гаргаж ажилла. Энэ тал дээр хөтөлбөрт 2.5 сая төгрөг тусгагдсан. Энэ ажил цаг хугацааны хувьд явагдаж байх ёстой. Үүн дээр анхаарч ажилла. Архинд донтох эмэгтэй иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах, сургалт, сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдэд хяналт шалгалт хийх ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан. Архинд донтох эмэгтэй 20 хүнийг албадан эмчилгээнд хамруулахаар төлөвлөсөн энэ ажлыг хэрэгжүүлэх тал дээр мөн анхаарч ажилла.	ХЭЗХ	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу заалт тус бүрээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС